

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 26

Дугаар 100

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Баянзүрх дүүргийн Хөгжлийн зураглал-2030 бодлогын баримт бичгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван долдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүргээс гадаад хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх сурагч солилцоо, оюутан тэтгэлгээр суралцуулах, эмнэлгийн ажилтнуудыг туршлага судлуулах хөтөлбөрийн оролцогчдыг сонгох журмыг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, шаардлагатай үйл ажиллагааг зохион байгуулж, шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлэж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан)-д зөвшөөрсүгэй.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг жил бүр Хуралд тайлагнаж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.Хөтөлбөрт оролцогчдыг сонгох журам

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2024
оны 04 дүгээр сарын 26-ны
өдрийн арван долдугаар
хуралдааны тогтоолын
хавсралт

ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОГЧДЫГ СОНГОХ ТУХАЙ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү “Хөтөлбөрт оролцогчдыг сонгох журам” (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Хурлаас гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор гадны улс, байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагаа санамж бичгийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн бүх шатлалын эмнэлгийн байгууллагад ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтныг онол, дадлага хосолсон ажлын байранд туршлага судлуулах, Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн 10, 11 дүгээр ангид суралцаж буй сурагчдыг солилцоогоор илгээх, оюутан тэтгэлгээр суралцуулах, шинэ технологийг өөрийн улс оронд нутагшуулах, сонгон шалгаруулалтыг ил тод оновчтой зохион байгуулах, тус журамд заасан шаардлага хангасан эмч, эмнэлгийн ажилтан, оюутан, сурагчдыг хамтын ажиллагааны хүрээнд гадаад улс оронд туршлага судлуулах, суралцуулах, Монгол Улсад тус улсаас сонгогдсон ирсэн эмнэлгийн байгууллагын эмч, ажилтан, оюутан, сурагчдыг солилцоогоор хүлээн авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Журмын хэрэгжилтэд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.3.Хөтөлбөрт оролцогчдын аюулгүй байдал, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагааны зохион байгуулалтыг хүлээн авч буй тал хариуцна.

Хоёр.Баримтлах зарчим

2.1.Оролцогчдод нээлттэйгээр нэгэн ижил мэдээлэл өгөх ба тэднийг эрх тэгш оролцох боломжоор хангана.

2.2.Солилцоогоор явуулах оролцогчдыг сонгохдоо хувийн үзэмж, үнэлэмжээр хандах, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн байдал, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно.

2.3.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтад оролцогчдын хувийн мэдээллийг цуглуулах, ашиглахдаа мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

2.4.Оролцогчдын бүртгэлийн талаарх мэдээллийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын зөвшөөрлийг үндэслэн байгууллагын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй мэдээлнэ.

Гурав.Оролцогчдод тавигдах шаардлага

3.1.Сурагч солилцооны хөтөлбөрт хамрагдах сурагчид дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги буюу 10, 11 дүгээр ангийн сурагч байх;
3.1.2. Баянзүрх дүүргийн байнгын оршин суугч байх;
3.1.3. Нээлттэй, дасан зохицох чадвартай, бие даасан байх;
3.1.4. Солилцоогоор илгээх улсаас хамаарч тухай бүр тусгайлан тавигдсан шаардлагыг хангасан байх.

3.2. Хамтын ажиллагааны хүрээнд туршлага судалж ажиллах эмнэлгийн ажилтан дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.2.1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн бүх шатны эмнэлэгт эмч, ахлах сувилагч, сувилагч, асрагч, сэргээн засагчаар ажилладаг байх;
3.2.2. Тухайн мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх;
3.2.3. Мэргэшил дээшлүүлэх сургалтад тогтмол хамрагдсан байх;
3.2.4. Цаашид тогтвор суурьшилтай ажиллах;
3.2.5. Баянзүрх дүүргийн байнгын оршин суугч байх;
3.2.6. Солилцоогоор илгээх улсаас хамаарч тухай бүр тусгайлан тавигдсан шаардлагыг хангасан байх.

3.3. Оюутан солилцоогоор суралцах оролцогчид дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.3.1. Ерөнхий боловсролын сургуулиа 90-ээс дээш үнэлгээтэй төгссөн байх;
3.3.2. Их, дээд сургуулийн 1 дүгээр курсийн оюутан байх;
3.3.3. Нээлттэй, дасан зохицох чадвартай, бие даасан байх ;
3.3.4. Баянзүрх дүүргийн байнгын оршин суугч байх;
3.3.5. Тэтгэлгээр суралцуулах улс, сургуулиас тэтгэлэг олгоход тавигдах шаардлагыг хангасан байх.

Дөрөв. Хөтөлбөрт оролцогчдыг сонгох

4.1. Оролцогчдыг дүүргийн харъяа хэлтэс, алба, тасаг, холбогдох төрийн бус байгууллага, дүүргийн Төлөөлөгчдөөс ирүүлсэн саналыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралд танилцуулан, гаргасан саналыг үндэслэн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга сонгоно.

4.2. Хөтөлбөрт оролцогчдыг дараах байдлаар сонгоно. Үүнд:

4.2.1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, харъяа хэлтэс, алба, тасаг, холбогдох Төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн оролцогчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авах, хянах;

4.2.2. Шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулга авах ;

4.2.3. Оролцогч шаардлага хангаж байгаа эсэх талаар холбогдох баримтад тулгуурлан санал, дүгнэлт, шийдвэр гаргах, шаардлагатай тохиолдолд ярилцлага хийх;

4.2.4. Сонгон шалгаруулалтын материалыг зохих журмын дагуу Хурлын Ажлын албаны архивт хүлээлгэн өгөх.

Тав. Томилолтоор ажиллах, сурах хугацаа

5.1. Хөтөлбөрт тэнцсэн оролцогчид дараах хугацаагаар туршлага солилцон ажиллаж, суралцана.

5.1.1. Сурагч солилцоогоор 3 долоо хоног хүртэл хугацаатай явуулах бөгөөд нэг хүүхдийг заавал Өнөр бүл хүүхдийн төвийн хүүхдүүдээс, нэг хүүхдийг хот,

тохижилт, нийтийн аж ахуйн салбарт ажиллаж буй үйлчилгээний албан хаагчдын хүүхдүүдээс, нэг хүүхдийг нийгмийн идэвхи оролцоо сайтай хүүхдүүдээс сонгох;

5.1.2.Оюутан солилцоо буюу тэтгэлэгээр 2.5-4 жилийн хугацаагаар суралцуулах ба нэг хүүхдийг заавал Өнөр бүл хүүхдийн төвийн хүүхдүүдээс, нэг хүүхдийг хот, тохижилт, нийтийн аж ахуйн салбарт ажиллаж буй үйлчилгээний албан хаагчдын хүүхдүүдээс, нэг хүүхдийг нийгмийн идэвхи оролцоо сайтай хүүхдүүдээс сонгох;

5.1.3.Эмнэлгийн байгууллагын эмч, ажилтныг солилцоогоор нэг жилд 2 удаа 14 хоногийн хугацаагаар тус тус туршлага судлуулна.

Зургаа.Зардал шийдвэрлэх

6.1.Хөтөлбөрт тэнцэж хамтын ажиллагаатай улсад туршлага судалж, суралцах эмч, эмнэлгийн ажилтан, оюутан, сурагчид, мөн хамтын ажиллагаатай улсаас сонгогдон Монгол Улсад туршлага судлах, суралцах зорилгоор ирж буй солилцооны эмч, эмнэлгийн ажилтан, оюутан, сурагчдын зардлыг санамж бичиг байгуулсан талууд бүрэн хариуцна.

6.2.Хөтөлбөрт оролцогчдыг илгээх, хүлээн авахтай холбогдон гарах зардлыг Хурлын төсөвт суулган, тухай бүр Ажлын албаны даргын тушаалаар шийдвэрлэнэ.

Долоо.Бусад

7.1.Оролцогчийн анкет болон бусад холбогдох материалыг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, үзүүлэхийг хориглоно.

7.2.Журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх аливаа маргааныг тухай бүр оновчтой шийдвэрлэнэ.

7.3. Журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.